



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/56

Сант сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн  
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, "Мал амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 8 дугаар зүйлийн 8.2.3, 9 дүгээр зүйлийн 9.1, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион тухай" 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны "Дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай" А/34, 2023 оны "Төлөвлөгөө, удирдамж батлах тухай" А/33 тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Үйлчилгээний жишиг үнэлгээ тогтоох тухай" 41 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 13 дугаар тогтоолын 3.1.5, 3.1.6, 3.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах, гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, лабораторийн оношилгоо шинжилгээ, үзлэг тандалт, ариутгал халдваргүйтгэл, мал эмнэлгийн цахим гэрчилгээ, өвчлөл, бүртгэл мэдээлэл, баталгаажуулалтын ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хяналт тавих зорилгоор сумын хэмжээнд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд чанарын өндөр түвшинд зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Мөнх-Эрдэнэ

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Оюун-Эрдэнэ

(Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Г.Анхбаяр

(Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн 1-р багийн Засаг дарга)

Б.Золбаяр

(Хушаат 2-р багийн Засаг дарга)

Боловсруулсан: *Д. далай*  
Хянасан: *Ч. далай*  
Хувь: *д*

О.Лхагвасүрэн  
(СантБаянхайрхан Мал эмнэлгийн үйлчилгээний  
нэгжийн эмч)

Ө.Ганбаатар  
(Бошгын булаг ХХК-н захирал)

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

3.1.Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчин гарах тархах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мал, амьтны өвчлөл, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, бүртгэх, мэдээлэх, хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэм цуглуулж, устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх

3.2.Халдварт шөвөг яр, сахуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг толгой тутамд 500 (таван зуу) төгрөгөөр тооцож аж ахуй нэгж, малчид, иргэдээс гаргуулах

3.3.Лабораторийн оношилгоо, шинжилгээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад эрсдэлтэй бүсийн мэдрэмтгий мал, амьтныг технологит хугацаанд бүрэн хамруулах


3.4.Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн аж ахуй нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох

3.5.Дархлаажуулах ажлыг аж ахуйн нэгж байгууллага, малчин, мал бүхий өрхийн мал тооллогод хамрагдсан малыг бүрэн хамруулах ажлыг багийнхаа хэмжээнд зохион байгуулж, зар хүргэн ажиллах

3.6.Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах

3.7.Арга хэмжээг товлोलт хугацаанд чанартай хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайланг тухай бүрт гарган санхүүжилтийн материалыг бүрдүүлэн сумын Засаг даргаар батлуулж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэх

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР